



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.

#### 2 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль тогтоомж

2.1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

3.2.Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулахтай холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

#### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."мэдээллийн систем" гэж мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг;

4.1.2."мэдээллийн сүлжээ" гэж хоёр, түүнээс дээш хэрэглэгчийн хооронд мэдээлэл илгээх, дамжуулах, хүлээн авах программ хангамж болон техник хэрэгслийн иж бүрдлийг;

4.1.3."мэдээллийн эзэн" гэж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.5-д заасан хүн болон тухайн мэдээллээр тодорхойлогдож байгаа хуулийн этгээдийг;

4.1.4."мэдээлэл ашиглах" гэж мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцахыг;

4.1.5."мэдээлэл боловсруулах" гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагаа, тэдгээрийн нийлбэрийг;

4.1.6."мэдээлэл цуглуулах" гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;

4.1.7."нийтийн мэдээллийн дэд бүтэц" гэж нийтийн мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахад ашиглаж байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг;

4.1.8."нийтийн мэдээлэл" гэж нийтийн мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг;

4.1.9."цахим баримт бичиг" гэж мэдээллийн системийг ашиглан үүсгэх, боловсруулах, хадгалах, илгээх болон хүлээн авах боломжтой мэдээллийг.

#### 5 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн үйл ажиллагааны зарчим

5.1.Нийтийн мэдээллийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- 5.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх;
- 5.1.3.мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх;
- 5.1.4.мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх;
- 5.1.5.нийтийн мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд эрх тэгш байх;
- 5.1.6.нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай, нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх;
- 5.1.7.нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ, НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ**

#### **6 дугаар зүйл.Нийтийн мэдээлэл хариуцагч**

- 6.1.Дараах байгууллага нийтийн мэдээлэл хариуцагч /цаашид "мэдээлэл хариуцагч" гэх/ байна:
  - 6.1.1.төрийн байгууллага;
  - 6.1.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд;
  - 6.1.3.хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд;
  - 6.1.4.олон нийтийн радио, телевиз;
  - 6.1.5.улс төрийн нам.
- 6.2.Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд нийтийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, удирдлага, зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай бусад арга хэмжээ авах үүрэгтэй.

#### **7 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ангилал**

- 7.1.Нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилна.
- 7.2.Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ.
- 7.3.Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ.
- 7.4.Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж үзнэ.
- 7.5.Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй.
- 7.6.Хаалттай болон хязгаарлалттай мэдээлэлд хамаарах төрийн болон албаны нууцтай холбогдох Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.
- 7.7.Нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

#### **8 дугаар зүйл.Нээлттэй мэдээлэл**

- 8.1.Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.
- 8.2.Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:
  - 8.2.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;
  - 8.2.2.чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;
  - 8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;
  - 8.2.4.хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;

- 8.2.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;
  - 8.2.6.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;
  - 8.2.7.албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;
  - 8.2.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;
  - 8.2.9.хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;
  - 8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.
- 8.3.Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:
- 8.3.1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;
  - 8.3.2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;
  - 8.3.3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;
  - 8.3.4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;
  - 8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;
  - 8.3.6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.
- 8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:
- 8.4.1.өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;
  - 8.4.2.төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;
  - 8.4.3.санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
  - 8.4.4.хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;
  - 8.4.5.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;
  - 8.4.6.таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
  - 8.4.7.цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;
  - 8.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;
  - 8.4.9.шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;
  - 8.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;
  - 8.4.11.худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;
  - 8.4.12.мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;
  - 8.4.13.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт;
  - 8.4.14.Засгийн газрын гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн талаарх мэдээлэл;
  - 8.4.15.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт;
  - 8.4.16.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл;
  - 8.4.17.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл;
  - 8.4.18.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;
  - 8.4.19.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ;
  - 8.4.20.төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан;
  - 8.4.21.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл;
  - 8.4.22.концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
  - 8.4.23.концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл,

концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл;

8.4.24.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл;

8.4.25.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо;

8.4.26.төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;

8.4.27.мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;

8.4.28.хууль тогтоомжид заасан бусад.

8.5.Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:

8.5.1.үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;

8.5.2.зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.

[/Энэ заалт ад 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:

8.6.1.олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;

8.6.2.эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;

8.6.3.хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;

8.6.4.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;

8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;

8.6.6.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;

8.6.7.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ;

8.6.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;

8.6.9.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;

8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;

8.6.11.барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;

8.6.12.тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал;

8.6.13.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;

8.6.14.шүүн таслах ажиллагааны дүн мэдээ;

8.6.15.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ;

8.6.16.улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл;

8.6.17.Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хүргүүлсэн тайлан, Монгол Улсад өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах байгууллагын талаарх мэдээлэл;

- 8.6.18.зүй ёсны монополизм аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгайл байдлтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт;
- 8.6.19.хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;
- 8.6.20.нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;
- 8.6.21.мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;
- 8.6.22.хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.
- 8.7.Энэ хуулийн 8.4.13, 8.4.14, 8.4.15, 8.4.16, 8.4.17, 8.4.18, 8.4.19, 8.4.20, 8.4.21, 8.4.22, 8.4.23, 8.4.24, 8.4.25, 8.6.7-д заасан мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 8.6.9, 8.6.12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 8.6.14-т заасан мэдээллийг Монгол Улсын дээд шүүх, энэ хуулийн 8.6.15-д заасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, энэ хуулийн 8.6.16-д заасан мэдээллийг улс төрийн нам, энэ хуулийн 8.6.17-д заасан мэдээллийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 8.6.18-д заасан мэдээллийг өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, энэ хуулийн 8.6.19-д заасан мэдээллийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хариуцан нээлттэй, ил тод байлгана.
- 8.8.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.
- 8.9.Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан тайлан, мэдээ, үр дүн, статистик мэдээллийг улирал, хагас жил, жилээр гаргах бөгөөд дараагийн улирал, хагас жил, жилийн эхний сард багтаан цахим хуудсандаа байршуулна.
- 8.10.Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, ажлын байрны сул орон тоо, мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн талаарх зэрэг бусад мэдээллийг мэдээлэл хариуцагч тухай бүр нь цахим хуудсандаа байршуулна.
- 8.11.Мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлт оруулснаас хойш ажлын гурван өдрийн дотор өөрчлөлтийг тусгаж, мэдээллийг шинэчлэн нийтэлнэ.
- 8.12.Мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран мэдээлэл хариуцагч цахим хуудас, мэдээллийн самбарыг заавал ажиллуулах ба цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангана.
- 8.13.Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах тохиолдолд тус мэдээллийг өгөх эх сурвалжийг цахим хуудсанд тодорхой заасан байна.
- 8.14.Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулж бүртгэл хөтөлнө.
- 8.15.Энэ хуулийн 8.4-т заасан мэдээллийг нээлттэй, ил тод байлгахтай холбогдсон нарийвчилсан харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна.
- 8.16.Энэ хуулийн 8.8-д заасан цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмыг Засгийн газар батална.
- 8.17.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.
- 8.18.Энэ хуулийн 8.17-д заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 8.19.Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

## **9 дүгээр зүйл.Хязгаарлалттай мэдээлэл**

- 9.1.Албаны нууцад хамаарах мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан үндэслэл, журамд заасны дагуу ашиглана.
- 9.2.Энэ хуулийн 7.3-т заасан хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:
- 9.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл;
- 9.2.2.төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл;
- 9.2.3.нээлттэй байлгах нь соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл;
- 9.2.4.хуульд заасан бусад.

9.3.Энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т зааснаас бусад хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна.

9.4.Энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан мэдээлэлтэй мэдээллийн эзний зөвшөөрөл авахгүйгээр эрх бүхий этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна.

9.5.Мэдээлэл хариуцагчид байгаа хязгаарлалттай мэдээллийг тухайн мэдээллийн эзэн өөрөө хэдийд ч авч ашиглаж болно.

9.6.Мэдээллийн эзэнээс зөвшөөрөл авахдаа дараах нөхцөлийг танилцуулна:

9.6.1.мэдээлэл авах зорилго;

9.6.2.мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;

9.6.3.мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;

9.6.4.авах мэдээллийн жагсаалт, мэдээлэл авах хэлбэр;

9.6.5.мэдээлэл боловсруулах, ашиглах хүрээ, хадгалах хугацаа;

9.6.6.мэдээллийг ил болгох эсэх;

9.6.7.мэдээллийг бусдад дамжуулах эсэх;

9.6.8.зөвшөөрлөө цуцлах хэлбэр.

9.7.Мэдээллийн эзэн зөвшөөрлөө хэдийд ч цуцалж болох бөгөөд зөвшөөрлөө цуцлахаас өмнө мэдээлэл хариуцагчийн тухайн мэдээллийг гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан ажиллагааг хууль ёсны гэж үзнэ.

9.8.Мэдээлэл хариуцагчийн худалдан авах ажиллагаа, тендер сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангах зорилгоор тендерт шалгарсан оролцогчийн зөвшөөрлийг үндэслэн тендерийн нууцлаагүй хэсгийг бусад оролцогчид ил болгоход энэ хуулийн 9.7 дахь хэсэг хамаарахгүй.

9.9.Мэдээллийн эзэн зөвшөөрлөө бичгээр өгч, цуцална.

9.10.Мэдээллийн эзэн Иргэний хуулийн 16, 17, 18, 19 дүгээр зүйлд заасан хүн бол түүнд хамаарах хязгаарлалттай мэдээллийг түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр өгнө.

9.11.Мэдээлэл хариуцагч нь хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлийг үндэслэн бусдад өгсөн, дамжуулснаа нотлох үүрэгтэй.

9.12.Төрийн байгууллага болон хуульд заасан бусад этгээд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлалттай мэдээллийг ашиглах бол мэдээллийн эзний зөвшөөрөл шаардахгүй.

9.13.Энэ хуулийн 9.12-т заасны дагуу мэдээлэл хариуцагч мэдээллийг гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан бол мэдээллийн эзэнд энэ талаар хуульд заасан журмын дагуу мэдэгдэл хүргүүлнэ.

9.14.Мэдээлэл хариуцагч хязгаарлалттай мэдээллийг ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтөлнө.

9.15.Энэ хуулийн 9.14-т заасан бүртгэлд хүсэлт гаргасан этгээд, он, сар, өдөр, мэдээллийн эзнийг тодорхойлох мэдээлэл, зөвшөөрөл өгсөн хэлбэр, баталгаажуулалт, он, сар, өдөр, цахим тодорхойлогч, байгууллага, албан тушаалтны хандсан он, сар, өдөр, авсан мэдээллийн агуулга, мэдээлэл авсан зорилго, мэдээлэл ашигласан этгээд нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, харилцах утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна.

9.16.Энэ хуулийн 9.13, 9.14-т заасан мэдэгдэл хүргүүлэх, бүртгэл хөтөлж журмыг Засгийн газар батална.

9.17.Хязгаарлалттай мэдээллийг гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан үйл ажиллагаа, мэдээлэл хүссэн бүртгэл болон дараах мэдээлэлтэй мэдээллийн эзэн танилцах эрхтэй:

9.17.1.мэдээлэл авсан этгээд;

9.17.2.авсан мэдээллийн жагсаалт, мэдээлэл авсан хэлбэр;

9.17.3.мэдээлэл авсан он, сар, өдөр;

9.17.4.тухайн мэдээллийг авах хууль зүйн үндэслэл.

9.18.Энэ хуулийн 9.17-д заасны дагуу гаргасан танилцах хүсэлтийг мэдээлэл хариуцагч хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор шийдвэрлэнэ.

9.19.Хязгаарлалттай мэдээллийг гүйцэтгэх ажлын хүрээнд эрх бүхий байгууллагад дамжуулсан бол энэ хуулийн 9.13, 9.17, 9.18 дахь хэсэг үйлчлэхгүй.

## 10 дугаар зүйл.Хаалттай мэдээлэл

10.1.Хаалттай мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:

- 10.1.1.төрийн нууцад хамааруулсан мэдээлэл;
  - 10.1.2.Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.3-т заасан мэдээлэл;
  - 10.1.3.хуульд заасан бусад мэдээлэл.
- 10.2.Хаалттай мэдээлэлтэй хуульд заасан үндэслэл, журмын дагуу танилцаж, ашиглаж, ил болгоно.
- 10.3.Хүнд хамаарах хаалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр хуульд заасан зорилго, нөхцөл, журмын дагуу ашиглана.

#### **11 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийг устгах, өөрчлөлт оруулах**

- 11.1.Мэдээлэл хариуцагч цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа нийтийн мэдээллийг дараах үндэслэлээр устгана:
- 11.1.1.тухайн мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглаагүй бол мэдээллийн эзний хүсэлтээр;
  - 11.1.2.хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр мэдээллийг устгахаар мэдээлэл хариуцагчид үүрэг хүлээлгэсэн;
  - 11.1.3.хуульд заасан бусад.
- 11.2.Энэ хуулийн 11.1-д зааснаас бусад тохиолдолд нийтийн мэдээллийг устгахыг хориглоно.
- 11.3.Өөрт хамаарах мэдээлэл нь алдаатай, буруу ташаа, худал байх тохиолдолд мэдээллийн эзэн мэдсэн даруйд мэдээлэл хариуцагчид мэдэгдэж, холбогдох нотлох баримтыг хүргүүлэн мэдээллийг үнэн зөв болгож, өөрчлөлт оруулах эрхтэй.

#### **12 дугаар зүйл.Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох**

- 12.1.Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, нээлттэй өгөгдөл болгож болно.
- 12.2.Энэ хуулийн 12.1-д заасан нээлттэй өгөгдлийг мэдээлэл хариуцагч өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ.
- 12.3.Нээлттэй өгөгдлийг төлбөртэй болон төлбөргүйгээр ашиглуулж болох бөгөөд хандахад хялбар байх, хуулах, эрэмбэлэх, хайлт хийх боломжтой байх, ашиглах нөхцөлийг тодорхойлсон байна.
- 12.4.Мэдээлэл хариуцагч өөрийн боловсруулсан нээлттэй өгөгдлийг тогтмол шинэчилж байна.
- 12.5.Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, ашиглах нөхцөл, журам, нээлттэй өгөгдөлд тавигдах шаардлага болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан Засгийн газар батална.
- 12.6.Нээлттэй өгөгдлийн жагсаалт, нээлттэй өгөгдлийг нийтлэх хугацааг Засгийн газар тогтооно.
- 12.7.Хууль болон энэ хуулийн 12.6-д заасан жагсаалтад заасан нээлттэй өгөгдлийг үнэ төлбөргүй нийтэлнэ.
- 12.8.Энэ хуулийн 12.6-д заасан жагсаалтад ороогүй, эсхүл нээлттэй өгөгдлийг нийтлэхээс өмнө авах хүсэлт гаргасан бол мэдээлэл хариуцагч нээлттэй өгөгдлийг төлбөртэйгээр өгч болно.
- 12.9.Энэ хуулийн 12.8-д заасан төлбөр тооцох аргачлалыг Засгийн газар батална.
- 12.10.Дараах тохиолдолд нээлттэй өгөгдлийг нийтлэхийг хориглоно:
- 12.10.1.тухайн нээлттэй өгөгдлөөр дамжуулан төрийн болон албаны нууц, хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжтой бол;
  - 12.10.2.тухайн нээлттэй өгөгдөл нь оюуны өмчийн эрхийг зөрчихөөр бол;
  - 12.10.3.тухайн нээлттэй өгөгдлийг нийтэлснээр хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөр бол;
  - 12.10.4.хуульд заасан бусад.
- 12.11.Нээлттэй өгөгдөл нь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн талаар ирүүлсэн гомдлыг мэдээлэл хариуцагч ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 12.12.Энэ хуулийн 12.11-д заасан үндэслэлээр гомдол ирүүлсэн тохиолдолд мэдээлэл хариуцагч нь тухайн нээлттэй өгөгдөлд хандах хандалтыг гомдол шийдвэрлэх хүртэл хугацаанд түр зогсооно.
- 12.13.Энэ хуулийн 12.11-д заасан гомдлыг хянан шийдвэрлэсэн мэдээлэл хариуцагчийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

### 13 дугаар зүйл. Хүн, хуулийн этгээд мэдээлэл авах

- 13.1. Хүн, хуулийн этгээд мэдээллийг хүсэлт гаргаж, эсхүл цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байршуулсан мэдээллийг хүсэлт гаргалгүйгээр тухайн цахим хуудсанд хандаж авч болно.
- 13.2. Нээлттэй мэдээлэл авах бол хүсэлтийг амаар болон бичгээр, хязгаарлалттай мэдээлэл авах бол хүсэлтийг бичгээр гаргана.
- 13.3. Цаасан болон хуульд заасны дагуу цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг бичгээр гаргасан хүсэлт гэж үзнэ.
- 13.4. Бичгээр гаргасан хүсэлтэд дараах мэдээллийг тусгасан байна:
  - 13.4.1. хүсэлт гаргагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр;
  - 13.4.2. хүсэлт гаргагчийн оршин суугаа, эсхүл оршин байгаа газрын хаяг, шуудангийн хаяг, харилцах утасны дугаар;
  - 13.4.3. хязгаарлалттай мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, мэдээллийн эзний зөвшөөрөл;
  - 13.4.4. мэдээллийн агуулга, мэдээлэл хүлээн авах хэлбэр.
- 13.5. Цаасан хэлбэрээр гаргах хүсэлтийг хүн гарын үсэг зурж, хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.
- 13.6. Хүн, хуулийн этгээдийн цахим хэлбэрээр гаргасан хүсэлт нь тухайн хүн, хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу таньж баталгаажуулах боломжтой байна.
- 13.7. Хүсэлт гаргагч хүн хүсэлтдээ хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол түүнийг төлөөлөн хууль ёсны төлөөлөгч нь гарын үсэг зурна.
- 13.8. Хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхийг нотлох баримт бичгийг хавсаргана.
- 13.9. Хүсэлтэд хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно.

### 14 дүгээр зүйл. Хүсэлт гаргагчийн эрх, үүрэг

- 14.1. Хүсэлт гаргагч мэдээлэл авах талаар дараах эрх эдэлнэ:
  - 14.1.1. мэдээлэл авах хэлбэрээ сонгох;
  - 14.1.2. нээлттэй мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, үндэслэлээ тайлбарлахгүй байх;
  - 14.1.3. мэдээлэлтэй холбогдсон асуудлаар нэмэлт тайлбар авах;
  - 14.1.4. мэдээллийн агуулгын талаар тайлбарлуулах;
  - 14.1.5. мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх;
  - 14.1.6. мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл мэдээлэл хариуцагчийн дээд шатны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол шүүхэд гомдол гаргах;
  - 14.1.7. мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох талаар холбогдох мэдээлэл хариуцагчид хүсэлт гаргах;
  - 14.1.8. хуульд заасан бусад.
- 14.2. Хүсэлт гаргагч мэдээлэл авах эрхээ хөндөгдсөн гэж үзвэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гомдол гаргаж болно.
- 14.3. Хүн, хуулийн этгээд мэдээлэл авах талаар дараах үүрэг хүлээнэ:
  - 14.3.1. хуульд заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх;
  - 14.3.2. мэдээлэл авах эрхээ эдлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
  - 14.3.3. авах мэдээллээ боломжит байдлаар тодорхойлсон байх;
  - 14.3.4. хуульд заасан бусад.

### 15 дугаар зүйл. Мэдээлэл авах хүсэлт бүртгэх, шийдвэрлэх

- 15.1. Мэдээлэл хариуцагч мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авч, бүртгэл хөтөлж, энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан үзэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:
  - 15.1.1. хүсэлтийг хүлээн авч, мэдээллээр хангах;
  - 15.1.2. хүсэлтийг холбогдох мэдээлэл хариуцагчид шилжүүлэх;
  - 15.1.3. хүсэлтийг буцаах.
- 15.2. Энэ хуулийн 15.1-д заасан бүртгэлд дараах зүйлийг тусгана:
  - 15.2.1. хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдийн нэр, харилцах утасны дугаар, хаяг;



- 15.2.2.хүссэн мэдээллийн товч агуулга;
- 15.2.3.хүсэлт хүлээн авсан, мэдээлэл өгсөн он, сар, өдөр, хэлбэр;
- 15.2.4.хүсэлтийг буцаасан тохиолдолд буцаасан үндэслэл, хэлбэр;
- 15.2.5.мэдээллийг бүрэн, эсхүл хэсэгчлэн өгсөн эсэх;
- 15.2.6.шаардлагатай бусад.

15.3.Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, эсхүл урд өмнө нь хариу өгсөн асуудлаар дахин хандсан, эсхүл хүсэлтэд дурдсан мэдээлэл байхгүй бөгөөд хүсэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх боломжгүй бол уг хүсэлтийг буцааж болох ба үндэслэлийг тодорхой заана.

15.4.Мэдээлэл хариуцагч тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, хуулиар нээлттэй, ил тод байлгах мэдээллийг хүн, хуулийн этгээдэд тэдгээрийн хүсэлтийг үндэслэн бүрэн гүйцэд, үнэн зөв, тодорхой өгнө.

15.5.Мэдээллийг амаар, бичгээр, цахим болон хуульд харшлахгүй бусад хэлбэрээр өгч болох бөгөөд хүн, хуулийн этгээдийг хүсвэл мэдээлэлтэй биечлэн танилцуулж болно.

15.6.Хуульд өөрөөр заагаагүй бол хүсэлтийг хүлээн авсан мэдээлэл хариуцагч мэдээллийг дараах хугацаанд өгнө:

- 15.6.1.шууд өгөх боломжтой мэдээллийг хүсэлтийг хүлээн авсан даруй;
- 15.6.2.энэ хуулийн 15.6.1-д зааснаас бусад мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор.

15.7.Тухайн мэдээллийн цар хүрээ, мэдээллийг бэлтгэх шаардлагатай хугацааг харгалзан энэ хуулийн 15.6-д заасан хугацааг тухайн мэдээлэл хариуцагчийн эрх бүхий албан тушаалтан ажлын 10 хүртэл өдрөөр сунгаж болно.

15.8.Хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийг төлөөлөх эрх бүхий хүнд мэдээллийг өгнө.

15.9.Мэдээллийг өгсөн он, сар, өдөр, хариу бэлтгэсэн албан тушаалтны нэр, мэдээлэл олгосон хэлбэр, мэдээллийг бүрэн, эсхүл хэсэгчилж өгсөн эсэх зэрэг мэдээллийг тусган бүртгэл хөтөлнө.

15.10.Цахим мэдээллийн сангаас авч болох мэдээллийн цахим холбоосыг хүсэлт гаргагчид мэдэгдсэнээр хүсэлтийг шийдвэрлэсэнд тооцно.

## **16 дугаар зүйл.Мэдээлэл өгөх үйлчилгээний зардал**

16.1.Хүн, хуулийн этгээд цаасан хэлбэрээр мэдээлэл авахдаа хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл өгөхтэй холбогдон гарсан зардлыг төлнө.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан зардал нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас ихгүй байна.

16.3.Хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авахад энэ хуулийн 16.1-д заасан зардлыг төлөх үүрэг хүлээхгүй.

16.4.Энэ хуулийн 16.1-д заасан зардлын хэмжээг энэ хуульд заасны дагуу мэдээлэл хариуцагч тогтоох бөгөөд зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журмыг Засгийн газар батална.

16.5.Энэ хуулийн 16.1-д заасан зардлыг хууль тогтоомжид заасан бусад төлбөр, хураамжтай давхардуулан авахгүй.

## **17 дугаар зүйл.Мэдээлэл авах эрхийг хангах талаарх мэдээлэл хариуцагчийн хүлээх үүрэг**

17.1.Мэдээлэл хариуцагч хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг хангах талаар дараах үүрэг хүлээнэ:

- 17.1.1.хүсэлт гаргагчийг хүлээн авч уулзах байр, хүсэлтийг хүлээн авах цагийн хуваарийг нийтэд мэдээлэх;
- 17.1.2.хуульд заасан журмын дагуу мэдээллийг хүн, хуулийн этгээд саадгүй авах нөхцөлийг бүрдүүлэх;
- 17.1.3.хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэр, үйл ажиллагааны талаар урьдчилан мэдээлэх;
- 17.1.4.мэдээлэл авах хүсэлт, түүнийг шийдвэрлэсэн үйл ажиллагааны талаарх бүртгэлийг хөтлөх;
- 17.1.5.мэдээлэл авах хүсэлтийг энэ хуульд заасан хугацаанд шийдвэрлэх;
- 17.1.6.мэдээлэл авах хүсэлтийг шийдвэрлэж, хариуг хүсэлт гаргагчийн сонгосон хэлбэрээр өгөх;
- 17.1.7.хүсэлтэд дурдсан мэдээлэл нь хаалттай, эсхүл хүсэлт гаргагчид хамаарахгүй хязгаарлалттай мэдээлэл бөгөөд мэдээллийн эзний зөвшөөрөлгүй бол, эсхүл хүсэлт нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол энэ талаар үндэслэл бүхий хариу өгөх;
- 17.1.8.энэ хуулийн биелэлтийг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг харьяалах дээд шатны байгууллагад жил бүр тайлагнах;
- 17.1.9.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг ил тод, нээлттэй байлгах, цахим хуудсаар нээлттэй мэдээлэлтэй

танилцах нөхцөлийг бүрэн ханган байршуулах, мэдээллийг тухай бүр шинэчлэх;

17.1.10.нээлттэй өгөгдлийн жагсаалтын дагуу төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд холбогдох нөхцөл, шаардлагыг хангасан нээлттэй өгөгдлийг энэ хуулийн 12.6-д заасан хугацаанд нийтлэх, тухай бүр шинэчлэх;

17.1.11.хуульд заасан бусад.

17.2.Мэдээлэл хариуцагч хүн, хуулийн этгээд мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦ**

### **18 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн дэд бүтэц**

18.1.Нийтийн мэдээллийн дэд бүтэц нь үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем, мэдээллийн сүлжээ болон нийтийн мэдээллийн сангаас бүрдэнэ.

18.2.Энэ хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем нь нийтийн мэдээллийн системд хамаарна.

18.3.Үндсэн систем нь суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд ашиглах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн төрийн мэдээлэл солилцооны систем байна.

18.4.Дэмжих систем нь үндсэн болон мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий бие даасан мэдээллийн систем байна.

18.5.Дэмжих системд дараах систем хамаарна:

18.5.1.танилт, нэвтрэлтийн систем;

18.5.2.нийтийн түлхүүрийн дэд бүтэц;

18.5.3.албан бичиг солилцооны дундын систем;

18.5.4.мэдээлэл солилцооны бүртгэлийн систем;

18.5.5.мэдэгдэл хүргэх систем;

18.5.6.төрийн үйлчилгээний нэгдсэн систем;

18.5.7.төлбөр тооцооны систем;

18.5.8.хуульд заасан бусад;

18.5.9.Засгийн газраас шаардлагатай гэж үзсэн бусад систем.

18.6.Мэдээлэл хариуцагчийн систем нь төрөөс баримтлах харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэл, мэдээллийн аюулгүй байдлын стандартад нийцсэн байна.

18.7.Мэдээлэл хариуцагч, хүн, хуулийн этгээд нь үндсэн болон дэмжих системд холбогдоход энэ хуулийн 18.11-д заасан болон бусад хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

18.8.Үндсэн системийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын шийдвэрээр үүсгэх бөгөөд тус системийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, хяналт тавина.

18.9.Мэдээлэл хариуцагч хоорондоо болон мэдээлэл хариуцагчаас хүн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр мэдээлэл солилцоходоо үндсэн системийг ашиглана.

18.10.Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журмыг Засгийн газар батална.

18.11.Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлалыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

18.12.Үндсэн системийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байршуулна.

18.13.Мэдээлэл хариуцагч нь хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэхдээ энэ хуулийн 18.3-т заасан үндсэн системээр дамжуулан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй.

18.14.Энэ хуулийн 18.13-т заасан мэдээллийг мэдээлэл хариуцагч энэ хуулийн 18.3-т заасан үндсэн системээс татан авч бүрдүүлнэ.

18.15.Мэдээлэл хариуцагчаас бусад хуулийн этгээд нь хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээг энэ хуулийн 18.11-д заасан нөхцөл, шаардлагыг хангаж, үндсэн болон дэмжих системийг ашиглан үзүүлж болно.

18.16.Энэ хуулийн 18.15-д заасан хуулийн этгээд үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх бол цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулна.

18.17.Энэ хуулийн 18.16-д заасан гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журмыг Засгийн газар батална.

18.18.Нийтийн мэдээллийн дэд бүтэц нь эрх бүхий байгууллагаас тогтоосон цагийн улсын эталоныг ашиглана.

18.19.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан үзүүлсэн үйлчилгээний төсөвт төвлөрүүлсэн орлогын 50 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг үндсэн болон дэмжих систем хөгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан төсвөөс санхүүжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

#### **19 дүгээр зүйл.Танилт, нэвтрэлтийн систем**

19.1.Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ хүн, хуулийн этгээдийг цахим гарын үсэг болон Засгийн газраас тогтоосон арга, хэрэгсэл бүхий танилт, нэвтрэлтийн системийг ашиглан танина.

#### **20 дугаар зүйл.Нийтийн түлхүүрийн дэд бүтэц**

20.1.Нийтийн түлхүүрийн дэд бүтэцтэй холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

#### **21 дүгээр зүйл.Албан бичиг солилцооны дундын систем**

21.1.Мэдээлэл хариуцагч хоорондоо албаны цахим шуудангаас бусад хэлбэрээр цахимаар албан бичиг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын системтэй холбогдож, ашиглана.

21.2.Хүн, хуулийн этгээд нь мэдээлэл хариуцагчтай албаны цахим шуудангаас бусад хэлбэрээр цахимаар албан бичиг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын системтэй холбогдож, ашиглаж болно.

#### **22 дугаар зүйл.Мэдээлэл солилцооны бүртгэлийн систем**

22.1.Үндсэн системээр илгээсэн, хүлээн авсан мэдээллийг илгээсэн, хүлээн авсан хугацаа, илгээгч, хүлээн авагч, мэдээллийн агуулгыг илэрхийлсэн дахин давтагдашгүй утга болон бусад мэдээллийг мэдээлэл солилцооны бүртгэлийн системээр бүртгэнэ.

#### **23 дугаар зүйл.Мэдэгдэл хүргэх систем**

23.1.Мэдээлэл хариуцагч мэдэгдэл хүргэх системийг ашиглан хүн, хуулийн этгээдэд дараах тохиолдолд цахим хэлбэрээр мэдэгдэл хүргэнэ:

23.1.1.хүн, хуулийн этгээдэд хамаарах хаалттай, хязгаарлалттай мэдээлэлд бусад этгээд хандсан;

23.1.2.мэдээлэл хариуцагчид гаргасан хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн явц, шийдвэрийн талаарх;

23.1.3.хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ авах шаардлага гарсан талаарх сануулга;

23.1.4.татвар төлөлт, торгох шийтгэлийн төлбөрийн талаарх;

23.1.5.ард нийтийн санал асуулга болон сонгуулийн санал өгөх өдрийн тов.

23.2.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 23.1-д зааснаас бусад хүлээн авч болох мэдэгдэл, түүнийг хүлээн авах боломжтой хэлбэрийн талаар хүн, хуулийн этгээдэд мэдээлж болно.

23.3.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан иргэний бүртгэлийн дугаараар хүнд, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаараар хуулийн этгээдэд цахим шуудангийн хаягийг хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр мэдэгдэл хүргэх системд үүсгэнэ.

23.4.Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 23.3-т зааснаас бусад цахим шуудангийн хаягийг мэдэгдэл хүргэх системд бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэж болно.

23.5.Хаалттай, хязгаарлалттай мэдээллийг гүйцэтгэх ажлын хүрээнд эрх бүхий байгууллагад дамжуулсан бол энэ хуулийн 23.1.1 дэх заалт үйлчлэхгүй.

#### **24 дүгээр зүйл.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем**

24.1.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем нь хүн, хуулийн этгээдэд нийтийн мэдээлэл, төрийн болон бусад үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх хэрэгсэл байна.

24.2.Мэдээлэл хариуцагч нь хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээгээ төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан үзүүлнэ.

24.3.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас олгох лавлагаа, тодорхойлолтын загварыг Засгийн газар батална.

24.4.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгосон давтагдашгүй дугаар бүхий цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.

#### **25 дугаар зүйл.Төлбөр тооцооны систем**

25.1.Төлбөр тооцооны системтэй холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

## 26 дугаар зүйл.Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ

26.1.Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээтэй холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

## 27 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн сан

27.1.Нийтийн мэдээллийн сан дараах төрөлтэй байна:

27.1.1.суурь мэдээллийн сан;

27.1.2.төрөлжсөн мэдээллийн сан;

27.1.3.байгууллагын мэдээллийн сан.

27.2.Суурь мэдээллийн санг хуулиар эрх олгогдсон байгууллага хуульд заасны дагуу үүсгэн бүрдүүлэх бөгөөд уг мэдээллийн сан нь анхдагч эх сурвалж байна.

27.3.Суурь мэдээллийн санд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6, 7, 8 дугаар зүйл, Геодези, зураг зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан мэдээллийн сан хамаарна.

27.4.Суурь мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн, эсхүл мэдээлэл хариуцагчаас хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрөлжсөн мэдээллийн санг үүсгэнэ.

27.5.Байгууллагын мэдээллийн санд суурь болон төрөлжсөн мэдээллийн сан хамаарахгүй, мэдээлэл хариуцагчийн дотоод үйл ажиллагаанд зориулсан мэдээллийн сан хамаарна.

27.6.Суурь болон төрөлжсөн мэдээллийн сантай давхардуулан мэдээллийн сан үүсгэхийг хориглоно.

27.7.Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг Монгол Улсын нутаг дэвсгэрт байршуулна.

27.8.Мэдээлэл хариуцагч суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

27.9.Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журмыг Засгийн газар батална.

27.10.Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сан нь нэгдсэн ангилал, код, тайлбартай байна.

27.11.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 27.10-т заасан нэгдсэн ангилал, код, тайлбарыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэдээлэл хариуцагчтай хамтран батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 28 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт

28.1.Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийг Засгийн газар батална.

28.2.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 28.1-д заасан ерөнхий төлөвлөлтөд нийцүүлэн байгууллагын нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийг гарган хэрэгжүүлнэ.

28.3.Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмыг Засгийн газар батална.

## 29 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн систем байгуулах

29.1.Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө дараах асуудлаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулна:

29.1.1.нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа;

29.1.2.нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашигтай байдал;

29.1.3.хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал;

29.1.4.аюулгүй, найдвартай байдлын шийдэл;

29.1.5.бусад шаардлагатай асуудал.

29.2.Энэ хуулийн 34.1.2-т заасан стратеги төлөвлөгөө болон нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ нь энэ хуулийн 28.1-д заасан ерөнхий төлөвлөлт, энэ хуулийн 32.1.10-т заасан баримтлах чиглэлтэй нийцсэн байна.

29.3.Энэ хуулийн 29.1, 29.2-т заасан үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## 30 дугаар зүйл.Цахим баримт бичиг үйлдэх

30.1.Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагч баримт бичгийг үйлдэх, дамжуулах, хүлээн авах, хадгалах, хамгаалах болон ашиглахдаа цахим баримт бичигт суурилна.

30.2.Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цахим хэлбэрээр харилцахдаа албаны цахим шуудан болон энэ хуулийн 21, 23, 24 дүгээр зүйлд заасан дэмжих системийг ашиглана.

30.3.Цахим хэлбэрээр үйлдэгдээгүй баримт бичгийг цахим баримт бичигт хөрвүүлж болно.

30.4.Цахим баримт бичиг хөтлөлтийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 34.2-т заасан журмаар зохицуулна.

30.5.Хуульд өөрөөр заагаагүй бол цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй нэгэн адил хүчинтэй байна.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ** **НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦ БОЛОН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛ** **АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО**

### **31 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн дэд бүтэц болон төрийн цахим үйл ажиллагааны талаарх Засгийн газрын бүрэн эрх**

31.1.Нийтийн мэдээллийн дэд бүтэц болон төрийн цахим үйл ажиллагааны талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл бий болгох, төрийн цахим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэх, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шинэчлэл хийх, хүний нөөцийн хөгжлийн төсөл, хөтөлбөр баталж хэрэгжүүлэх;

31.1.2.нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам батлах;

31.1.3.хуульд заасан бусад.

### **32 дугаар зүйл.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

32.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

32.1.1.нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаа, нээлттэй өгөгдлийн талаар төрөөс баримтлах бодлого, нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийг боловсруулах;

32.1.2.нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаа, нээлттэй өгөгдлийн талаарх хууль тогтоомж, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

32.1.3.нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагааны талаар хуулиар эрх олгосны дагуу дүрэм, журам, заавар, аргачлал баталж, хэрэгжилтийг хангах;

32.1.4.үндсэн систем, дэмжих системийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авах;

32.1.5.нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагааны талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

32.1.6.хариуцсан асуудлаар олон улс, бүс нутаг, гадаад улсын нийтийн мэдээллийн системийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

32.1.7.нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх;

32.1.8.энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу мэдээлэл хариуцагчийн хэрэгжүүлэх нийтийн мэдээллийн системд зөвлөмж, дүгнэлт гаргах;

32.1.9.нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт тавих;

32.1.10.нийтийн мэдээллийн дэд бүтэц, нээлттэй өгөгдөл хөгжүүлэхэд ашиглах технологийн талаар баримтлах чиглэлийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

32.1.11.суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, нээлттэй өгөгдлийн бүртгэл хөтлөх;

32.1.12.Үндэсний дата төвийн дүрэм, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан төсвийн хүрээнд бүтэц, орон тоог батлах;

32.1.13.мэдээлэл хариуцагчийн нийтийн мэдээллийн систем, цахим үйл ажиллагаа хариуцсан нэгж, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

32.1.14.үндсэн систем, дэмжих системд холбогдох журам, заавар, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллах;

32.1.15.үндсэн систем, дэмжих систем, төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийг хариуцах;

32.1.16.нээлттэй өгөгдөл бий болгох талаар мэдээлэл хариуцагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

32.1.17.нээлттэй өгөгдлийн нөхцөл, шаардлага, стандарт боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах;

32.1.18.нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаа, нээлттэй өгөгдлийн талаар олон нийтэд сурталчлах, иргэний харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ, сургалт зохион байгуулах;

32.1.19.энэ хуулийн 8.16-д заасан цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журмын төсөл боловсруулах;

32.1.20.энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж, чиглэл өгөх;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32.1.21.хуульд заасан бусад.

[/Энэ заалтын дугаарт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

32.2.Энэ хуулийн 32.1.4, 32.1.13, 32.1.14, 32.1.15, 32.1.16, 32.1.18-д заасан чиг үүргийг бусад этгээдээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгүүлж болно.

## **32<sup>1</sup> дүгээр зүйл.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага**

[/Энэ зүйлийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.1.хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх ажлыг шуурхай зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.2.төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний талаар баталсан хууль тогтоомж, Засгийн газар болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэр, дүрэм, журмыг дагаж мөрдөх, хэрэгжилтийг зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.3.өөрийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.4.төрөөс үзүүлж байгаа үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.5.төрийн үйлчилгээ хүргэх ажлыг боловсронгуй болгох арга хэмжээг авах, бусад байгууллага, гадаад улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.6.хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хариу мэдэгдэх үүрэг бүхий үндсэн болон бусад системтэй холбогдон ажиллах дэд системийг хөгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.7.орон нутгийн хэмжээнд төрийн үйлчилгээг хүргэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.8.гадаад улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээ хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, холбогдох бусад арга хэмжээг тогтмол зохион байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.1.9.хуульд заасан бусад.

[/Энэ заалтыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.2.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг нь суурь мэдээллийн сан хариуцсан төрийн байгууллагаас бусад төрийн байгууллагын энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан чиг үүргийг хариуцан хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.3.Энэ хуулийн 32<sup>1</sup>.2-т заасан байгууллага нь орон нутагт салбар, нэгжгүй төрийн захиргааны болон Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын үйлчилгээг хариуцан хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.4.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог баталж, нийслэл, орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн даргыг томилж, чөлөөлнө.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.5.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь энэ хуулийн 32<sup>1</sup>.4 дэх хэсэгт заасны дагуу баталсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан тус байгууллагад ажиллах албан хаагчдыг томилж, чөлөөлж, орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн бүтэц, орон тоог батална.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.6.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нийслэл, орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн дарга нь тус байгууллагад ажиллах албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.7.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж ажиллана.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.8.Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь газар, хэлтэс, тасгаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам болон үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар батална.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

32<sup>1</sup>.9.Энэ хуулийн 32<sup>1</sup>.1.1, 32<sup>1</sup>.1.6, 32<sup>1</sup>.1.8-д заасан зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж болно.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

### **33 дугаар зүйл. Үндэсний дата төв**

33.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд Үндэсний дата төв ажиллана.

33.2.Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, түүний нөөцийг Үндэсний дата төвд хадгална.

33.3.Байгууллагын мэдээллийн сангийн нөөцийг Үндэсний дата төвд хадгалж болно.

33.4.Мэдээлэл хариуцагчийн системийг Үндэсний дата төвд байршуулж болно.

33.5.Үндэсний дата төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

33.5.1.үндсэн системээр мэдээлэл солилцох холболт үүсгэх;

33.5.2.үндсэн системд холбогдох хуулийн этгээдийн мэдээллийн системд тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг боловсруулах;

33.5.3.үндсэн болон дэмжих системийн үйлдлийн бүртгэл үүсгэх, хадгалах, хамгаалах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

33.5.4.хуульд заасан бусад.

33.6.Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд стандартын шаардлагыг хангасан дата төв байгуулж болох бөгөөд Үндэсний дата төвтэй үйл ажиллагаагаа уялдуулна.

### **34 дүгээр зүйл.Мэдээлэл хариуцагчийн нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаар хүлээх үүрэг**

34.1.Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаар дараах үүрэгтэй:

34.1.1.үндсэн систем, дэмжих системд холбогдсон мэдээллийн системийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах;

34.1.2.салбарын болон байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөтэй байх;

34.1.3.хариуцаж байгаа мэдээллийн системд хийгдсэн үйлдлийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

34.1.4.чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд үүссэн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах;

34.1.5.хариуцаж байгаа мэдээллийн санг хүн, хуулийн этгээдээс цахим хэлбэрээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

34.1.6.нээлттэй өгөгдлийг мэдээллийн системд уншигдах хэлбэрээр байршуулж, хүн, хуулийн этгээд ашиглах боломжийг бүрдүүлэх, төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд холбох;

34.1.7.хариуцаж байгаа мэдээллийн системийг энэ хуулийн 18.11-д заасан нөхцөл, шаардлагыг хангаж нийтийн мэдээллийн дэд бүтцэд холбох;

34.1.8.өөрийн чиг үүрэгт хамаарах үйлчилгээг цахим хэлбэрээр болон нийтийн мэдээллийн дэд бүтэц ашиглан хүн, хуулийн этгээдэд үзүүлэх;

34.1.9.мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр энэ хуулийн 27.8-д заасны дагуу бүртгүүлэх;

34.1.10.хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагчийн систем ашиглах болон байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, аюулгүй байдлыг дотооддоо хангахтай холбогдсон журмыг батлах;

34.1.11.нийтийн мэдээллийн дэд бүтцийн талаарх хууль тогтоомж, Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг харьяа байгууллагын хэмжээнд хангах.

**ДОЛДУГААР БҮЛЭГ**  
**НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЭЦ БОЛОН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛ**  
**АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

**35 дугаар зүйл. Нийтийн мэдээллийн дэд бүтэц болон төрийн цахим үйл ажиллагааны талаарх хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг**

35.1. Нийтийн мэдээллийн дэд бүтэц болон төрийн цахим үйл ажиллагааны талаар хүн, хуулийн этгээд дараах эрхтэй:

35.1.1. нийтийн мэдээллийн сан дахь өөрт хамаарах мэдээлэлтэй танилцах, хуулбарлаж авах, дамжуулах;

35.1.2. мэдэгдэл хүлээн авах хэлбэрээ сонгох, энэ хуулийн 23.1-д зааснаас бусад мэдэгдлээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзах;

35.1.3. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрээр болон нийтийн мэдээллийн дэд бүтэц ашиглан авах.

35.2. Нийтийн мэдээллийн дэд бүтэц болон төрийн цахим үйл ажиллагааны талаар хүн, хуулийн этгээд дараах үүрэгтэй:

35.2.1. мэдээллийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарлалттай мэдээллийг ашиглах;

35.2.2. хуульд заасны дагуу олж авсан хязгаарлалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахгүй, задруулахгүй байх;

35.2.3. нийтийн мэдээллийн дэд бүтэцэд ашигладаг нэвтрэх нэр, нууц үг, бусад хамгаалалтын арга, хэрэгслийн нууцлалыг бусдад задруулахгүй байх;

35.2.4. нийтийн мэдээллийн дэд бүтэц болон хүний нууцлалсан буюу хамгаалагдсан систем, мэдээлэлд халдахгүй, доголдол үүсгэхгүй байх, бусдын эрх, нууц үгээр нэвтрэхгүй байх;

35.2.5. нийтийн мэдээллийн дэд бүтэцэд ашигладаг нэвтрэх нэр, нууц үг, бусад хамгаалалтын хэрэгслийн нууцлал зэргийг алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, зөвшөөрөлгүй этгээд ашигласан, гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн, эсхүл өөрийнх нь зөвшөөрөлгүй нэвтэрсэн тохиолдолд даруй нийтийн мэдээллийн систем хариуцагчид мэдэгдэх.

**НАЙМДУГААР БҮЛЭГ**  
**БУСАД ЗҮЙЛ**

**36 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

36.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

36.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**37 дугаар зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт**

37.1. Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө нийтийн мэдээллийн системийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацаанд энэ хуульд заасан шаардлагыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

37.2. Энэ хуулийн 37.1-д заасан этгээд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гэрээ шинэчлэн байгуулах хүсэлтийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж, гэрээ байгуулна.

**38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

38.1. Энэ хуулийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР